

ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**ХЯТАДАД ФЕОДАЛИЗМ УРТ УДААН ХУГАЦААГААР
НОЁРХСОН ТУХАЙ АСУУДЛЫН СУДАЛГААНД****Роман Славиньски (БНПАУ)**

Хятадад феодализм урт удаан хугацаагаар ноёрхсон тухай асуудлаар энэ зууны 30-аад онд тус оронд маргаан эхэлсэн юм. Энэ асуудлаар янз бүрийн үзэл бодол гарч байв. Хятадад 2 мянга гаруй жил феодализм ноёрхсоны үндсэн шалтгааныг хятадын зарим районы хооронд солилцоо явагдаагүй байснаас худалдаа, гар урлал хөгжөөгүйгээс болсон гэх буюу эсвэл боловсруулах газрын хэмжээнээс хэтэрсэн хэт олон хүн амтай болохгүйг эрмэлзсэнээс болсон гэдэг хүчин зүйлийг анхаарч байлаа.

Энэ маргаан «соёлын хувьсгал»-ын үед намжсан боловч дараа нь дахин гарав. Энэ талаар зарим шинэ үзэл бодол бий болсоныг Тянь Цзюйцзянь¹ дараах таван үндсэн үзэл бодолд хувааж байна. Үүнд:

1. Хятад нь нийгэм-улс төр, эдийн засгийн болон үзэл суртлын нэгдсэн системтэй байв. Эдгээрийн хоорондын нягт уялдаа холбоо нь феодалын нийгмийн хөгжилд тус болсонгүй, харин ч саад болов. Лю Цинфэн, Цзинь Гуаньтао нар нь энэ үзэл бодлыг баримтлагчид юм. Тэд дээрх нэгдсэн системийг «хэт тогтвортой»² систем гэж тодорхойлж байгаа бөгөөд чухам энэ нь Хятадад феодалын нийгэм урт удаан хугацаагаар ноёрхсоны гол шалтгаан болсон гэж үзэж байна. Нийгмийн албан ёсны үзэл, соёлын уламжлал болох феодалын эдийн засаг, хүнд суртал, улс төрийн нэгдмэл систем, кунзын сургаал нь хоорондоо маш нягт холбоотой байсан бөгөөд энэ нь хятадыг феодалын «хэт гүрэн»³ болж хувирахад тус дөхөм үзүүлжээ. Уг гүрэн хоёр чухал шинжтэй байв. Нэгдэх шинж нь феодалын туйлын дорой аж ахуйн нөхцөлд ухамсрын болон улс төрийн бүтцийг өндөр хэмжээнд хослуулсан явдал юм. Энэ байдал нь эцэс сүүлдээ уг системийн аль нэг салбар хэлбэлзэхэд феодалын хэт гүрнийг мөхөхөд хүргэдэг байлаа. Хоёрдох шинж нь уг гүрэн оршин тогтносон байдлаа хангахын тулд дээр өгүүлсэн гурван системийн эв нэгдлийг хадгалахад чиглэсэн улс төрийн төрөл бүрийн арга хэмжээ авахад хүрдэг байв.

Дээрх зорилгыг биелүүлэхэд зохицуулах 2 механизм үйлчилж байлаа. Үүнд:

Нэгдэх нь улсыг төлөөлсөн эзэн хааны роль юм. Эзэн хаан нь хүнд сурталтнуудыг үе залгамжилсан язгууртнууд болгохгүйг хичээж, нийт нийгмийн хувьд, ялангуяа «сөрөг байгууллага» бий болгохгүйн тулд эрс арга хэмжээ авч байв. Хоёрдох зохицуулагч механизм нь тариачны бослого байв. Эзэн хаан «сөрөг байгууллагыг» хяналтандаа

¹«Лиши янцзю , 1982, № 1, хуудас 103—110

²«Гуйян Шиюань сюэбао». 1980, № 1. 2.

³Мөн тэнд.

бүрэн авч чадахгүйд хүрэхэд тариачны бослого дэгддэг байв. Тариачны бослогын дараа бүх юм маш хурдан хэвийн байдалд эргэж ордог байлаа. Тариачны бослого нь нэг талаар хуучин эзэн хааны засгийг сольдог нөгөөтэйгүүр феодалын байгууллыг бэхжүүлдэг байв.

2. Ван Цуньцайгийн⁴ үзэл бодол нь Тянь Цзюй Цзянийнхтай нэлээд төстэй байна. Түүний гол санаа бол феодалын жижиг тариачны аж ахуй нь феодалын хэмжээгүй эрхт засгийн системийн үндэс мөн гэдэгт оршино. Тариачны бослого феодалын ноёрхолд цохилт өгдөг байсан боловч бүхэлдээ феодалын нийгмийн ноёрхлын үндэс болох жижиг тариачны аж ахуйг хадгалахад тус дөхөм үзүүлж байв.

3. Хятад дахь феодалын байгуулал нь хэзээ ч төгс хэлбэрээ олоогүй байсан учраас үйлдвэр, худалдаа хөгжих нөхцөл бүрэлдээгүй байв. Уг үйл явцын энэ төгс биш байдал нь нийгмийн хямрал гарах хатуу ширүүн залхаан цээрлүүлэлт өрнүүлэхэд хүргэдэг байв. Энэ бол Лю Чанын⁵ үзэл бодол юм. Тэр түүнийгээ дараах янзаар тайлбарлаж байна. Үүнд: Захирагч хаад газрыг өөрсөддөө бөөгнөрүүлэн эзэмшсэн нь тариачдын байдлыг хэт хүндрүүлж тэмцэлд босоход хүргэдэг байв. Үүний үр дүнд шинэ засаг тогтож, түүний дараа дахиад л тоо томшгүй жижиг аж ахуйтнууд бий болж, эзэн хааны юугаар ч хязгаарлашгүй засаг, хэмжээгүй эрхт байгуулал сэргэн мандаж нийгмийг феодалжуулах үйл явц анхныхаа байдалд эргэн ордог байлаа. Энэ үзэл бодлыг Чжоу Цинцзи⁶ баяжуулахдаа Хятадад феодалжих үйл явц, өөрөөр хэлбэл феодалын том аж ахуйн хөгжил болон чөлөөт тариачдыг феодалын хөрөнгө үйлдвэрлэгчид болгон хувиргасан нь өөдрөг шулуун шугамаар явсан биш, харин зүсэн бүрийн эргэлттэй тулгарч байснаас феодалжих үйл явц Хятадад 2 мянган жил сунжирчээ. Суны хаанчлалын үед энэ үйл явц үндсэндээ дууссан боловч үндэсний асуудал хурцдаж тариачны бослого байнга өрнөж байсан нь түүнийг дахин саатуулсан учраас тэр нь нэн шинэ түүхийн үе хүртэл үргэлжлэв.

4. Харин Чэнь Хун⁷ бол Хятадад төгс феодалжих үйл явц бүр дээд төвшинд байснаас чухамхүү энэ байдал л нийгмийн шинэ хэлбэршилд шилжихэд саад болсон юм гэж үзэж байна. Газрыг нэгээс нөгөөд шилжүүлж, нийгмийн хямрал үе үе давтагддаг байсан нь байнгын зохицуулагч 2 арга болж байв. Феодалын эдийн засгийн өндөр хөгжлийн энэ тогтвортой бус байдал нь түүний онцлог шинж юм. Түүний үр дүн бол ерөнхийдээ феодализмын эдийн засгийн «тогтвортой» бүтцийг бий болгож, хятадад феодалын байгууллын ерөнхий хямрал гарахыг хойшлуулж байсан явдал мөн.

Энэ үйл явцад төв засгийн газраас сөрөг хүчнийхээ эсэргүүцлийг дарж, хээл хахууль авдаг байсан хүнд сурталтнуудыг огцруулах замаар зөрчлийг зөөлрүүлж, шинэ хүмүүсийг шалгалтын системээр шилэн авч эцэст нь нэг хаанчлалыг нөгөөгөөр сольдог байсан явдал тус дөхөм үзүүлжээ.

Чэнь Хунын үзэж байгаагаар ноёлогч үзэл суртал тогтворгүй байдлаас тогтвортой байдалд шилжиж байжээ. Өөрөөр хэлбэл олон янзын шашин, философийн олон сургууль ажиллаж, дотоод, гадаадын үзэл санаа холилдож байсан нь ноёлогч үзэл сурталыг байнга шинэчлэн, дээрх тогтворгүй байдал нь байнгын үзэгдэл болж, энэ нь хэт тогтвортой үзэл сурталыг бий болгоход ямагт хүргэдэг байлаа.

⁴ «Сюешу юэкань», 1981 № 10

⁵ «Шанхай шифань сизюань сюэбао» 1980, № 4, Лиши янцзю 1981, 2

⁶ «Хэбэй шифань сюэбао» 1981. № 1

⁷ «Фудань сюэбао» 1981, № 4.

5. Эцэст нь Ху Цичуаний⁸ сүүлийн үеийн үзэл бодол юм. Хятадын феодалын эдийн засаг нь аажмаар бүрэлдэн тогтож, аажмаар өмхрөн ялзарсан бөгөөд үүний хамгийн гол шалтгаан бол газарзүйн нөхцөл байсан юм. Феодал-газрын эздийн аж ахуй нь эхлээд Төв Хятадын тэгш тал газарт Цинь болон Ханы хаанчлалын үед хөгжиж, III—IV зууны хооронд бусад үндэстний хавчилт шахалтын уршгаар хүн амын анхны нүүдэл улс орны өмнөд зүг рүү их болж, харин дараа нь хойт Суны хаанчлалын (X—XI зууны) үед хүн ам дахин нүүдэллэн холилджээ. Хүн ам ингэж өмнө зүг рүү шилжин суурьшсан нь феодалын байгууллын газар нутагт бодитойгоор тэлж, феодалын үйлдвэрлэлийн аргыг өргэжүүлжээ.

Хятадын газар нутаг бүхэлдээ өргөжин тэлж байсан үйлдвэрлэлийн процесс бэхжиж байв. Ингэх нөхцөл байхгүй болмогц, тухайн төрийн мөхөх үе үргэлжилж байлаа.

Гэвч Хятад дахь жижиг хөрөнгөтний олон тооны аж ахуй бүхэлдээ феодалын байгууллыг бэхжүүлж бэйжээ. Ялангуяа уламжлалт хөдөө аж ахуйгаа хүндэтгэдэг, өрнөдтэй адил капитализмын хөгжлийн хүч хэрэглэх хэлбэр (тухайлбал, колонийг тонон дээрэмддэг арга)-ийг хэрэглээгүй зэрэг нь хятадад капитализмын эх үүсвэр нэлээд эрт бий болсон ч гэсэн урт удаан хугацаагаар хадгалагдахад хүргэжээ.

Сүүлийн үед Хятадад гарч байгаа өвөрмөц бөгөөд шинэ үзэл бодлын товч жагсаалтаас дээрх чухал асуудлаар зарим бодлоо хэлэхийг хүсч байна.

1. Хятадад феодалжих үйл явцын асуудлаар дээр дурьдсан зарим үзэл бодол олон янз, эсвэл өөр хоорондоо хэдийгээр зөрчилтэй байгаа ч гэсэн хамгийн гол нь урьдахь хэдэн арван жилийг бодвол тариачны бослогын роль уг бослого хятадад феодалын байгууллын ноёрхлыг үнэн хэрэгтээ батжуулахад чухлаар оролцсон асуудалд огт өөрөөр хандаж байгаа явдал юм.

2. Хэт тогтвортой бүтэц, хэт гүрний тухай үзэл бодол бидний онцгой анхаарлыг татаж байна. Үнэндээ тийм бүтэцтэй байсан нь тухайн байгуулал урт удаан хугацаагаар оршин тогтнож ноёрхоход тус дөхөм болдог ажээ. Хэрэв төв засгийн газар (эзэн хаан) түшмэлүүдийг өөртэйгээ өрсөлдөгч, бие даасан язгууртан болгож хувиргахгүй барьж чаддаг байсан бол төр засгийн газар жижиг тариачны тоо томшгүй олон аж ахуйн жуучлалгүйгээр ноёрхож чадах байсан бөгөөд энэ нь хаанчлалын солигдол, тариачны хөдөлгөөний томоохон ялалтаас хамаарахгүйгээр феодалын байгууллыг тогтворжиход бас тус дөхөм болох байлаа.

3. Эдгээр үзэл бодолд хятадын уламжлалт нууц нийгэмлэгүүдийн ролийг үгүйсгэж байгаа мэт санагдана. Хятадын нийгмийн түүх нь зөвхөн хаанчлалын түүх биш бөгөөд харин оршин тогтнож байсан феодалын «албан ёсны» дэглэм нь янз бүрийн талтай байсан юм. Ялангуяа нууц нийгэмлэгүүдийн үйл ажиллагаа нь хэдийгээр хязгаарлагдмал, «шударга захирагч»-тай болох тухай мөрөөдлийн уламжлал гэх зэрэгтэй байсан ч гэсэн бүхэлдээ хятадын нийгмийн хөгжлийн үйл явцад бодит тус дөхөм үзүүлжээ. Тэдний үйл ажиллагаа байгаагүй байсан бол тариачны тэмцэл зөвхөн урсгалаар явагдах байжээ. Зарим хаанчлалын засгийг түлхэн унагасан ялгуусан бослогын амжилтыг (хэсэг хугацаагаар ч атугай) бататгасан нийгмийн зохион байгуулалттай (овог, омог, нууц нийгэмлэгүүдийн) систем байсан учраас тариачны энэ урсгал тэмцэл утга учиргүй байгаагүй юм.

⁸ Цзинцзи яньцзю», 1981, № 6.

4. Хятадад феодализм урт удаан хугацаагаар ноёрхсон тухай асуудал нь хоёр талтай байна. Үүнд а. Энэ тухай Тянь Цзицзянь одоо үед феодалын үлдэгдэлтэй тэмцэх шаардлагын тухай ХКН-ын зохих баримтанд түшиглэн бичиж байна. б. Хэдийгээр феодалын ч гэсэн хятадын төвлөрсөн хүчирхэг улс байсан шалтгааныг (нийгмийн хямралтай байсан ч гэсэн) судлах нь судалгааны төдийгүй практик ач холбогдолтой зүйл гэж үзэж байна. Урьдах нийгмийн хямралууд газрыг нийгмийн өмч болгон үлдээсэн ч гэсэн айл өрх бүрийг бүтээгдэхүүн тушаах хариуцлагын системтэй болгож, өөрөөр хэлбэл хөдөө тосгонд жижиг үйлдвэрлэгчдийг шинээр тоо томшгүй бий болгосон нь төв засгийн газрыг бэхжүүлэх зорилтыг үнэхээр дахин тавьсан ч байж болох юм.

Ер нь ямар ч байлаа гэсэн Хятадад феодализм урт удаан хугацаагаар ноёрхсон шалтгааны талаар эрдэм шинжилгээний маргааныг сэргээсэн нь эрдэм шинжилгээний болон практикийн багагүй ач холбогдолтой учир түүхчид-хятад судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж байна.